

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХҮНИЙ СЭТГЭЦЭД УЧИРСАН ХОР УРШГИЙГ НӨХӨН ТӨЛӨХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

NEEDS AND REQUIREMENTS FOR THE DEVELOPMENT OF LEGAL REGULATIONS FOR COMPENSATION FOR DAMAGES CAUSED TO THE HUMAN MENTAL STATE AS A RESULT OF CRIMES

Б.Хонгорзул

Шихихутуг их сургуулийн

Харьцуулсан эрх зүйн хүрээлэнгийн судлаач

Товч агуулга: Энэхүү судалгааны ажлын хүрээнд аливаа гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг хууль эрх зүйн хүрээнд хэрхэн тогтоож, түүнийг үнэлж, шүүхийн журмаар нөхөн төлж байгаа тухай онолын үндэслэлийг судалж, практикт гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг барагдуулах хууль эрх зүйн хэрэгжилт ямар түвшинд байгаа талаар гадаад улсын сайн жишгээс харьцуулан судалж, хууль зүйн шинжлэх ухааны норматив арга болон нийгмийн хүсэл зоригийг илэрхийлж нарийвчилсан оновчтой байдлаар авч үзэх үүднээс анализ, синтез хийх аргыг ашиглаж, энэ төрлөөр судалгаа хийсэн зарим улс орны хууль эрх зүйн хэм хэмжээ, шүүхийн шийдвэрүүдэд харьцуулсан судалгаа хийж, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

Abstract: This research aims to study the theoretical basis for how the harm caused to the human psyche by any crime is determined in the legal framework, evaluated, and compensated through judicial procedures, and to compare the level of legal implementation of the harm caused to the human psyche by crime with good foreign standards, and to use the normative method of legal science and the method of analysis and synthesis to express the will of society in a detailed and rational manner, and to conduct a comparative study of the legal norms and court decisions of some countries that have conducted research of this type, and to determine the solution.

Түлхүүр үг: Сэтгэцэд учирсан хор уршиг, сэтгэцэд учирсан хохирлыг нөхөн төлөх, үнэлэх, аргачлал.

Keywords: Psychological harm, compensation for psychological damage, evaluation, methodology.

Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлөхтэй холбоотой ойлголт, эрх зүйн зохицуулалтын онцлог

Гэмт хэргийн үүсэл хөгжил нь нийгмийн тодорхой хэрэгцээ шаардлагаас үүдэн хувьсан өөрчлөгдөж тэрхүү нийгмийн хувьсал өөрчлөлтийн нөлөөллөөр өнөөдрийг хүрсэн. Тухайн нийгмийн өөрчлөлт шинэчлэлт, хүн амын хөдөлмөр эрхлэлт, боловсрол эзэмшилтийн түвшин, ажил эрхлэлтийн байдал, давамгайлж буй шашин шүтлэг, хүн амын амьжиргааны байдал зэрэг олон хүчин зүйлтэй уялдуулан ялын бодлого, эрх зүйн хэм хэмжээ өөрчлөгддөг.

Манай улсын хувьд эрүүгийн эрх зүйн салбарын хөгжил, хууль зүйн салбарт үзүүлэх нөлөө, бусад хууль тогтоомжуудтай уялдах уялдаа холбоо, ялын бодлого нь харьцангуй тогтвортой түвшинд хурдацтай хөгжиж аливаа гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шүүхээр шийдвэрлэх, нөхөн төлөх, шүүхийн шийдвэр түргэн шуурхай хэрэгжих байдал сайжирсаар байгаа хэдий ч зарим асуудал дээр гурван шатны шүүх хоорондоо зөрүүтэй

ойлголт үүсгэдэг ба хэрэгжих байдал нь хүндрэлтэй журам аргачлалууд олон байна. Үүнд гарцаагүй гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг тогтоох, үнэлэх, нөхөн төлөхтэй холбоотой маргаан тулгамдсан асуудал болоод байгаа юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэн бүр эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг заасны дагуу бусдын хууль бус хохирол гэдэгт эдийн болон эдийн бус хохирол хамаардаг болохыг Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болоод бусад холбогдох хууль тогтоомжуудаас харах боломжтой. Үүнээс үзвэл, манай улсын шүүхийн практикт саяхныг хүртэл зөвхөн материаллаг буюу бодитоор хохирсон хохирлыг үнэлж тогтоон шүүхээр шийдвэрлэдэг байсан нь шүүн таслах ажиллагааны процесс бодитой хэрэгжих, гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчид хохирлоо бүрэн барагдуулах эрх зүйн орчин бүрдээгүй байсныг харуулж байна.

Энэ төрлийн хууль зүйн орчныг манай улсад бүрдүүлэх эхний шаардлага нь юун түрүүнд хууль зүйн нэр томьёоны зөрүүтэй ойлголтыг арилгах, шүүх шинжилгээний багт мэргэжлийн хүмүүсийг оролцуулан дүгнэлт гаргах түвшинд ажиллуулснаар сэтгэцэд учирсан хор уршгийг үндэслэлтэй тогтоох, бодитой дүгнэлт гаргах, тэдний гаргасан дүгнэлт санал нь энэ төрлийн маргаантай асуудлаар онолын түвшний судлагдахуун болж Монгол Улсын хэмжээнд хэрэгжих хууль тогтоомж, журам аргачлалын түвшинд хүрэх боломжтой юм. Учир нь энэ судлагдахуун нь хууль зүйн хүчин чадлаар баталгаажиж, түүгээр хамгаалагдаж байгаа эрх ашиг боловч сэтгэл судлалын шинжлэх ухааны оролцоо, салбарын мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр хуульд хийдэлгүй хуульчлагдах, шүүхийн шатанд хэрэгжих хэрэгжилт сайжрах юм.

Сэтгэл судлал нь хүний зан үйл, сэтгэцийн шинж байдал, ухамсрын нарийн үйлдлүүд болох сэтгэл хөдлөл, хүмүүсийн харилцаа зэргийг судалдаг хосолмол шинжлэх ухааны нэгдэл юм. Өөрөөр хэлбэл, сэтгэл судлалын шинжлэх ухаан нь нарийн төвөгтэй олон асуудлыг өөртөө багтаасан байдаг буюу үүний нэг нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал ба энэ нь хууль зүйн нэр томьёоны хувьд сэтгэцэд учирсан хор уршиг хэмээн томъёологдож байгаа юм.

Австрийн эрдэмтэн Зигмунд Фройд 1890-1939 он хүртэл өөд болох хүртлээ сэтгэл заслын арга буюу психоанализыг хөгжүүлсэн бөгөөд Фройд оюун санааг клиникийн ажиглалт, өөрийгөө шинжих болон тайлбарын арга дээр үндэслэн танин мэдэж байсан бөгөөд хүний ухамсаргүй үйлдэл, истери, психопатологи буюу сэтгэцийн эмгэг дээр гол судалгаагаа төвлөрүүлсэн байна. Хүний оюун санаа, бие махбод, үйл хөдлөлийн илэрхийлэмжийн илрэн гарч ирж буй гадаад хэлбэр нь сэтгэцийн эрүүл мэндийн асуудал буюу гадны хүчин зүйлийн нөлөөллөөр гэмтэл авсан хүн сэтгэл санааны хямралд өртөх, амьдралын идэвх буурах, нийгмийн харилцаанд оролцох нь багасах гэх мэт хор уршгууд нь сэтгэцэд учирсан хор уршиг юм.

Ийнхүү тодорхойлж байгаа нь хууль зүйн талаас шүүмжлэлтэй асуудал хэдий ч хохирол гэдэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.¹ Харин эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг хор уршигт тооцно.² Өөрөөр хэлбэл, бодитой учирсан хохирол байснаар хор уршиг яригдах боломжтой болж байгаа юм. Гэвч зарим төрлийн гэмт хэргийн улмаас бодит хохирол учраагүй байсан ч хор уршиг учрах боломжтой гэмт хэргүүдийг Эрүүгийн хуульд заасан байгаа нь хууль

¹ “Монгол Улсын Эрүүгийн хууль” 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

² “Монгол Улсын Эрүүгийн хууль” 2.5 дугаар зүйлийн 2 дэх хэсэг

хэрэглээний зөрүүтэй байдал бий болох цаашлаад гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлж, тогтооход бэрхшээлтэй болж байгаа юм. Үүнээс уялдуулан дүгнэвэл, аливаа төрлийн гэмт хэргийн улмаас бодитой учирч буй хохирол нь сэтгэл санааны гэм хор бөгөөд үүн дотор урт хугацаандаа хүний амьдралын чанар нөлөөлөх, богино хугацаанд илрэн гарахгүй ч ирээдүйд бий болох сөрөг үр дагавар нь сэтгэцэд учирч буй хор уршиг болж байгаа юм. Энэхүү судлагдахууныг дан ганц хууль зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлах нь учир дутагдалтай бөгөөд холбогдох салбар шинжлэх ухааны тусламжтайгаар тайлбарлан хуульчлах нь илүү оновчтой буюу хууль хэрэглээний хувьд ч цэгцтэй болж байгаа юм.

Аливаа гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг тодорхойлох, үнэлэх практик туршлагатай болсноор нөхөн төлөх арга механизм боловсронгуй болж иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг эдлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалах хууль эрх зүйн орчин бүрдэж байгаа юм. Гэмт хэргийн улмаас учирсан хохиролтой холбогдолтой нэхэмжлэлийг тухайн эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байхад иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэхийг хуулиар хязгаарладаг. Энэ нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй” гэсэн зарчим үйлчилдэг. Гэхдээ эдгээр зарчим нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэх тухай асуудлыг хэлэлцэж байгаа буюу гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдох хүртэл гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй байх тухай яригдана. Өөрөөр хэлбэл, тухайн этгээдийн хийсэн үйлдэл нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хангаагүй байсан ч тодорхой үйлдлийн улмаас бусдын сэтгэл санаа, сэтгэцэд хохирол учирсан тохиолдолд түүнийг Иргэний шүүхээр нэхэмжлэх нь тусдаа эрх зүйн харилцаа юм. Гадаадын ихэнх улсад хохирогч хамгааллын нарийн хууль тогтоомжийн үндсэн дээр аливаа этгээдийн үйлдлийн улмаас бусад сэтгэцийн эмгэг үүсээгүй ч хохирол учирсан байх боломжтой тул гэмт хэрэг мөн эсэхээс үл хамааран үйлдлийнх нь төлөө нөхөн олговор олгох асуудал яригдана. Үүнээс улбаалан нөхөн олговор, нөхөн төлбөр, нөхөн сэргээлт гэх өөр ойлголтууд гарч ирж байна. Үүнээс үзвэл, Эрүүгийн эрх зүйн салбарт шинэ судлагдахуун гарч ирж байгаа нь цаашдаа салбар эрх зүйн хүрээнд зарчим, нэр томъёоны хувьд багагүй эргэлзээ үүсгэж эхэлж байгаа юм.

Учир нь аливаа гэмт хэргийн нийгэмд аюултай шинж чанарыг тогтоох нэг үндсэн шинж нь гэмт үйлдлийн улмаас бодитой учирсан хохирол, хор уршиг юм. Дээрх агуулгууд дээр үндэслэн сэтгэцэд учирсан хор уршиг, сэтгэл санааны хохирол, эдийн бус гэм хор гэх агуулгууд нь ямар ялгаа заагтай болох, манай улсад ямар байдлаар тодорхойлогдсон болох, бусад улсуудын хуульд хэрхэн хуульчлагдсан байгааг харьцуулан судалж дүгнэлт хийе.

Сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлөхтэй холбоотой харьцуулсан судалгаа

Манай улсын хувьд гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлөхтэй холбоотой асуудал нь харьцангуй шинэ сэдэв бөгөөд сүүлийн 4-5 жил сэдвийг олон өнцгөөс судалж судлаач бүр өөр өөрсдийн үзэл санааг гаргасан олон судалгаа гарсан ч тэр бүр Монгол улсын хууль тогтоомж, одоо хэрэгжиж байгаа журам аргачлалд тэр бүр ач холбогдолтой биш байсаар байна.

Дэлхийн бусад улс оронд энэ төрлийн маргаан нь хүний үндсэн эрхийн салшгүй нэг хэсэг нь болж тусгайлсан хууль тогтоомжтой хүртэл байдаг. Аливаа төрлийн маргаантай асуудал дээр улсын хэмжээнд нэг аргачлал ашиглах, эсхүл тогтсон нэг хуультай болох гэдэг бол практик үзүүлэх үр өгөөжийн хувьд харьцангуй ялгаатай. Өөрөөр хэлбэл, хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлөхдөө байнгын бус шинжтэй дүрэм аргачлал ашиглах нь

хийдэл гарах, нөгөө талаас иргэний зөрчигдсөн эрхийг хүн бүрт адил сэргээх нөхөн төлөх нөхцөл бүрдэхгүй юмаа. Иймд манай улсын хувьд гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлөхтэй холбоотой аргачлалыг дангаар нь ашиглах бус энэ төрлийн харилцааг зохицуулдаг бие даасан хуультай болох шаардлага үүсэж байна. Дэлхийн зарим улсад сэтгэцэд учирсан гэм хорыг нөхөн төлөх аргачлал байдаг ба түүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн бие даасан хуульч мөн байдаг байна.

Оросын Холбооны Улсад сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн журмаар олгодог байна.³ Нөхөн төлбөрийг олгохдоо тухайн буруутай үйлдэл үйлдсэн этгээдээс нэхэмжилдэг. Эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашигладаг ба ОХУ-ын Иргэний хуулийн 151 дүгээр зүйлд “Хэрвээ тухайн иргэнд эдийн бус хохирол учруулсан эсвэл хуульд заасан бусад тохиолдолд шүүх гэмт этгээдэд учруулсан эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай шийдвэр гаргаж болно” гэж заасан. Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо шүүх гэмт этгээдийн гэм буруу болон бусад нөхцөл байдлыг анхаарч авч үздэг.

ОХУ-ын одоогийн шүүхийн практикт хууль тогтоомжоор зохицуулагдсан, эсхүл ОХУ-ын дээд шүүхээс удирдамж болгосон сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх хэмжээг тогтоох аргачлал байхгүй хэдий ч зарим аргачлалыг шүүхийн практикт хэрэглэдэг байна. Тухайлбал, А.М.Эрделевскийн зохиосон хүснэгтийг⁴ шүүхийн практикт хэрэглэж байна. Сэтгэл санааны нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход $D=d*fv*i*c*(1-fs)$ томъёог ашиглахыг эрдэмтэн судлаач Эрделевский санал болгож байна.

$D=d*fv*i*c*(1-fs)$ • D –Сэтгэл санааны хохирлын нийт дүн;

- d - Сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ;
- fv – Гэмт этгээдийн үйлдсэн гэм хорын хэмжээ. Гэм хор нь 0-ээс их 1-ээс бага байна $0 \leq fv \leq 1$;
- i – хувь хүний онцлог. 0-ээс их 2-оос бага $0 \leq i \leq 2$;
- c – анхаарч үзвэл зохих нөхцөл байдал. 0-ээс их 2-оос бага $0 \leq c \leq 2$;
- fs – хохирогчийн гэм буруутай байдал. 0-ээс их 1-ээс бага $0 \leq fs \leq 1$.

АНУ-ын хувьд мужийн хууль тогтоох байгууллагаас байгуулсан “Гэмт хэргийн хохирогчдод зориулсан нөхөн олговрын сан”-ын хамрах хүрээ, сангийн хөрөнгийн эх үүсвэр, нөхөн төлбөр авах хэмжээ, хүсэлт гаргах процесс зэргийг тайлбарласан ба тус улсын муж болгон өөр өөрийн хохирогчдын нөхөн төлбөрийн сантай байдаг.⁵ Энэ сангийн ач холбогдол нь аливаа гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлөхөд зориулагдсан буюу улсын хэмжээнд нэг сангийн хөрөнгөөс бүх хүний хохирлыг барагдуулах нь иргэдэд чирэгдэл учруулах, цаг хугацааны хувьд урт хугацаанд үргэлжлэх, хохирлоо барагдуулахаар удаан хугацаанд хүлээх асуудал үүсдэг нь наад захын асуудал болдог байна. Манай улсын хувьд одоогийн байдлаар тухайлсан хохирогчид зориулсан нөхөн олговрын сан байхгүй ч засгийн газрын тусгай сангаар дамжуулан шийдвэрлэдэг ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар зүйлд мөн зааснаар төрийн албан хаагчийн буруутай үйл

³ УИХ.МН судалгааны сан, ХЭҮК-оос хийсэн суурин дүн шинжилгээ “Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн зохицуулалт”

⁴ Б.Д.Завидов. Моральный вред. 2001., С 21-24

⁵ Монгол Улсын дээд шүүх “Сэтгэцэд учирсан хор уршгийг арилгуулах эрх зүйн орчин: асуудал, шийдэл” хэлэлцүүлэгт хэлэлцүүлсэн АНУ-ын Техас мужийн Рөүзбуд хотын шүүхийн ерөнхий шүүгч Мэтью Г.Райт, Форт Уорт хотын Вановер дүүргийн 8 дугаар шүүхийн эрүүгийн хэргийн шүүгч Чарлз Чак нарын хэлэлцүүлсэн илтгэл.

ажиллагааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна хэмээн заасан байдгаас хохирогчийн нөхөн олговрыг тухайлсан хуулиар бус холбогдох бусад хууль тогтоомжуудаар шийдвэрлэдэг нь манай улсын нэгэн тулгамдсан асуудал болоод байгаа юм. Үүнээс үзвэл, гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлөхөд тусгай сантай болох цаашлаад энэ сангийн хөрөнгө нь улсын хэмжээнд бус орон нутаг бүр өөр өөрийн нөхөн олговрын сантай болох шаардлагатай буюу гагцхүү энэхүү сангуудын хөрөнгийг хянах нэг системтэй байх нь зөв юм.

Ингэснээр бусад улсуудын жишгээр шүүхийн процесс дуусахыг хүлээхгүйгээр нөхөн олговроо урьдчилж авах, шүүхээр холбогдогч этгээдийн гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд үлдэгдэл нөхөн олговрыг авах боломжтой байгаа юм. Өөрөөр хэлбэл, урьдчилсан байдлаар нөхөн олговор авч хохирогч этгээдэд учирсан хохирлыг нэмэгдүүлэхгүй байх зохих арга хэмжээг авч байгаа үйлдэл юм. Цаашлаад манай улс аливаа төрлийн гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлөх тусгайлсан даатгалтай болох боломжтой. Энэ даатгалын систем нь улсын төсөвт учруулах хүндрэл багатай, мөн хохирогч болон гэмт хэрэг үйлдсэн байх болзошгүй гэж үзэж байгаа сэжигтэн хоёрт харилцан ашигтайгаар ажилладаг систем юм.

Олон улсын жишгээс харахад манай улстай ойролцоо төрлийн журам, аргачлал, томьёо гэх мэт зүйлсийг энэ төрлийн харилцаанд ашигладаг улсууд олон байгаа ч тухайн улсын онцлог нь хохирогчид учирч буй хохирлыг үнэлж хохирлын зэрэглэлээр тогтоодог буюу ижил төрлийн гэмт хэргийн хохирогч өөр өөр сэтгэл санааны шаналал зовуурь мэдрэх боломжтой гэдгийг хүлээнэ зөвшөөрч мөн нэг гэмт хэрэг дээр хохирлын шатлалаар үнэлгээг тогтоохгүйгээр шууд учирсан хохирлоор нь тогтоож байгаа юм. Үүнийг нарийвчлан тайлбарлавал, дээрэмдэх гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн хувьд ямар эд хөрөнгөө дээрэмдүүлж байгаагаас шалтгаалан сэтгэл санаанд учрах хохирлын хэмжээ өөр өөр байдаг. Өөрөөр хэлбэл, манай улсын хэрэглэж байгаа аргачлалын хувьд зарим гэмт хэрэг нь сэтгэцэд хохирол учрах боломжгүй сэтгэл санааны хохирол гаргуулах боломжгүй гэмт хэрэг байдаг. Энэ мэтчилэн хүний амь нас, эд хөрөнгө, цаашдын амьдралын баталгаа гэх мэт үнэ цэнтэй зүйлийг шийдвэрлэж байгаа асуудалд сохроор хандах нь учир дутагдалтай буюу олон сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй юм.

Эдгээр арга хэмжээг цогцоор нь авч хэрэгжүүлснээр хохирогчийн сэтгэл санаа, сэтгэцэд учирсан хохирлыг барагдуулахад олон хэлбэрээр оногдуулах боломжтой буюу олон улсын жишгээс харахад нөхөн олговор, нөхөн сэргээлт, нөхөн төлбөр гэх төрлүүдээр олгох боломжтой юм.

Нөхөн олговор гэх ойлголт нь хүний эд хөрөнгө, эрх ашиг, эрүүл мэнд нэр төр гэх мэт хохирол учирсан тохиолдолд тухайн хохирлыг арилгах зорилгоор төлж буй төлбөр юм. Өөрөөр хэлбэл, аливаа этгээдэд учирсан хохирлыг бодит байдлаар үнэлэн хуучин хэвд нь ортол сэргээж чадахгүй буюу түүнийг орлуулж үнэлж байгаа тохиолдлыг нөхөн олговор гэнэ. Ихэвчлэн гэмт хэргийн улмаас үүссэн хохирол, бусад зөрчлийн шинжтэй үйлдлүүд дээр нөхөн олговор яригдах нөхцөл үүсдэг.

Нөхөн төлбөрийн тухайд авч үзвэл аливаа гэрээний дагуу эсхүл хууль зөрчсөн үйлдлийн улмаас бусдын эрх ашгийг зөрчсөн тохиолдолд үүсдэг мөнгөн төлбөр буюу өөрөөр хэлбэл, нөхөн төлснөөр өмнөх байдалдаа сэргэх эсхүл орлуулж болохуйц хохирлыг нөхөн төлбөр хэмээн үзэж мөнгөөр болон бусад эд материалаар дүйцүүлэн олгодог. Мөн эдгээр ойлголтуудаас гадна нөхөн сэргээлт гэх ойлголт яригдана. Учир нь нөхөн сэргээлт нь гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгахад мэргэжлийн баг ажиллуулах нь эдийн бус хохирлыг барагдуулах нэг хэлбэр юм.

Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага

Манай улсад одоогийн байдлаар сэтгэцэд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр төлөх ба хохирогчид учирсан биеийн болон сэтгэцийн зовлон шаналлын шинж чанар, хохирол учруулсан нөхцөл байдал зэргийг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг шүүх тогтоож байхаар хуульчилсан байна. Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос сэтгэл санааны хохирлын хэмжээг тооцох аргачлалыг 2016 онд боловсруулсан төсөл байдаг.

Ингэхдээ:

- Алдагдсан боломжийн үнэлгээ
- Сэтгэл санааны хохирлын үнэлгээ

- Шууд зардал буюу баримтаар нотлогдох бодит хохирлуудыг багтаан эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол үнэлгээг тодорхой томьёонд оруулан тооцоолох байдлаар бодож тооцохоор тогтоосон аргачлалыг санаачлан боловсруулж байсан байна.

Учир нь гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн талаарх олон нийт болон хуулийн байгууллагынхны ойлголт, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт, аргачлал болон үнэлэлт дүгнэлт хийх мэргэжлийн хүний нөөцийн чадвар, судлагдсан байдал зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалж шүүхийн шинжилгээний сэтгэц судлал нь олон улсын төвшинд сүүлийн 30 жилийн хугацаанд л эрчимтэй хөгжиж буй салбар юм. Олон улсын туршлагаас үзэхэд сэтгэл судлаачийг хорих байгууллагад ажиллуулснаар хоригдлуудын гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг тооцоолох, товч намтар үүсгэх, хувь хүний онцлогийн талаар мэдээллийн сан бий болгох, нийгэмшүүлэх, сэтгэл зүйд нь эергээр нөлөөлөх засрал хүмүүжлийн арга хэмжээ авахаас гадна хорих ангийн ажилтнуудад зөвлөмж, сэтгэл зүйн эмчилгээ үзүүлж байна⁶.

Мөн сэтгэл судлаач нь цагдаагийн мөрдөгч нарт хохирогчтой хэрхэн зөв харьцах, түүнийг хэрхэн ойлгох, мэдүүлгийг чанартай авахад туслалцаа үзүүлэх зорилгоор сургалт хийдэг. Ялангуяа бага насны хүүхэд хохирсон гэмт хэргийн хувьд сэтгэл судлаачийн тусгай сургалтад хамрагдаж хүүхэдтэй харьцах арга барил эзэмшинэ. Харин прокурор, шүүхийн байгууллагад ажилласнаар хохирогчийг шүүх танхимд мэдүүлэг өгөхөд бэлдэх, түүний мэдүүлгийн үнэн зөвийг үнэлэх, хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоох, сэтгэцийн хор уршгийг тогтоох, эмчилгээний нөхөн төлбөрийн хэмжээ, хугацаа, сэтгэлзүйн эмчилгээний аргын талаар дүгнэлт гаргах зэргээр ажиллаж байна.

Үүнээс харвал, аливаа төрлийн гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг тогтоож үнэлэхийн тулд зөвхөн хуулийн байгууллагын оролцоотойгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах бус заавал сэтгэл судлаач, сэтгэл зүйчийн мэргэжлийн баг оролцуулах хэрэгцээ шаардлага тулгараад байгаа юм. Учир нь техник технологийн эрин үед технологийн ур чадвар өндөр түвшинд хөгжсөн ч хүн хоорондын харилцаа үүсэхгүйгээр сэтгэц, сэтгэл санаанд учирсан хохирол, хор уршгийг тогтоох нөхцөл бүрэлдээгүй байгаа.

Зарим судлаачдын хувьд сэтгэцэд учирсан хор уршгийг сэтгэл санааны гэм хорын нэг хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд энэ агуулгын хүрээнд маргаантай хэд хэдэн асуудал хөндөгдөж байна. Учир нь эрүүгийн эрх зүйн салбарын хувьд сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах буюу хор уршгийн тухай асуудал хөндөгдөж, түүнтэй уялдуулан 2023 онд Эрүүл мэндийн сайд,

⁶ Улсын Ерөнхий Прокурор “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг нөхөн төлүүлэх шинжилгээ эрүүгийн хуулийн зорилготой холбогдох нь” 2022 он.

Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал” батлагдан гарсан.

Хор уршиг нь хохирлын улмаас үүссэн үр дагавар байна хэмээн тодорхойлсон бөгөөд хохирол учрахгүйгээр хор уршиг учрах боломжтой буюу объектгүй гэмт хэргийн тухай асуудал хөндөгдөнө. Аливаа төрлийн гэмт хэргийн улмаас бие дээр ил харагдах шарх сорив, эд хөрөнгө болон бусад төрлийн бодит хохирол гараагүй ч тухайн гэмт хэргийн улмаас айж цочирдох, сэтгэл зүйн эмгэгтэй болох, түгших, амьдралын чанар муудах зэрэг олон хор уршиг гарах боломжтой.

Цаашлаад Иргэний хуульд 2022 оны 12 сарын 23-ны өдөр Шүүхийн шинжилгээний тухай хуульд шинэчилсэн найруулга орсонтой холбоотойгоор нэмэлт өөрчлөлтүүд орсон. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт орсноор сэтгэцэд учирсан гэм хор гэх ойлголтыг оруулсан. Үүнээс үзвэл, гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршиг болоод иргэний хуульд заасан сэтгэцэд учирсан гэм хорын объект нь өөрөөр тодорхойлогдох тухай яригдана.

Дүгнэлт

Орчин үед дэлхий нийт техник технологийн өндөр хөгжилтэй уялдан хүн амын төвлөрөл, үйлдвэржилтийг дагасан амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгийн эрсдэл нийгмийн аюулгүй байдал зэргээс шалтгаалан бий болсон хүний эрхийг хангах түүний зөрчигдсөн эрхийг хамгаалах үүднээс улс орнууд эрх зүйн тогтолцоондоо гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол, хор уршгийг арилгах асуудал түүнийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн хувьд нарийн тогтолцоог улам боловсронгуй болгон хөгжиж байна. Эрх зүй өндөр хөгжсөн зарим улс оронд гэм буруутай этгээдээс сэтгэл санааны хохирлыг нэхэмжилж барагдуулах, гэм буруутай этгээд тогтоогдоогүй бол эд хөрөнгө бие эрхтэнд учирсан хохирлоос гадна сэтгэл санаанд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлж барагдуулдаг ба олон улсын сайн жишгээс өөрийн улсад зохих хэмжээнд хэрэгжүүлбэл зохистой байна.

Судлагдсан улс орнуудын туршлагыг харахад шүүхээр дан ганц хохирол барагдуулахаас гадна бусдад учруулсан хор уршгийг арилгах учирч болзошгүй аюулыг саармагжуулахын тулд гэм хорын даатгалын тогтолцоог хөгжүүлж, хохирлыг нийт нийгэмд тараан үүрүүлэхээс гадна тухайн хохирогчид гэм хорыг төрийн албан хаагчийн зүгээс учруулснаас болон үүсэх сэтгэл санааны хохирлыг төр бас давхар хариуцах бүрэн боломжтой байгаа нь олон улсын жишгээс харагдаж байна.

Түүнчлэн зарим улсад эдийн бус хохирлын хэмжээг тусгайлсан хуулиар тогтоон хохирлыг барагдуулдаг төдийгүй эдгээр зохицуулалтад нийтлэг байдлаар тодорхой гэмт хэргийн улмаас бий болсон сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр төлөх ба хохирогчид учирсан биеийн болон сэтгэл санааны зовлон шаналлын шинж чанар, хор уршиг учруулсан үеийн нөхцөл байдал зэргийг харгалзан нөхөн төлбөрийн хэмжээг мөнгөн дүнгээр илэрхийлэн дээд болон доод хэмжээг тусгаж тогтоосон хэмжээнд шүүх нотлох баримтыг үнэлэн нөхөн төлбөрийн хэмжээг ногдуулж байхаар хуульчилсан байна. Энэ жишгээр ихэнх улсад гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан учирсан хор уршгийг тооцон барагдуулахдаа 50,000-125,000 мянган ам.доллараас эхлээд олон сая ам.доллараар тооцож хохирлын нөхөх төлбөрийг барагдуулж байна.

Монгол Улсын тухайд Улсын дээд шүүхээс гаргасан тайлбар, тогтоолууд тодорхой бус, гурван шатны шүүх хооронд зөрүүтэй байдлаар хэргийг шийдвэрлэж байгаа зэрэг тулгамдсан асуудлууд үүсэж байгаа бөгөөд үүнийг холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, шат шатны байгууллагуудаас гаргаж буй шийдвэрүүдэд хяналт тавьж тодорхой ахиц дэвшил

гаргах шаардлагатай байгаа юм. Иймд гадаадын улс орны сайн туршлагыг албан ёсны харилцааны шугамаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хамтын ажиллагааны хүрээнд хүсэлт тавин гаргуулан авч өөрийн орны нийгэм эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинжлэх ухааны онол арга зүйн үүднээс судалж хүний эрхийн суурь зарчимд бүрэн нийцүүлсэн байр сууринаас боловсруулан үр дүнг практикт нэвтрүүлэх нь манай хууль зүйн шинжлэх ухааны өмнө тулгарч буй нэн тэргүүний асуудал болсон байна.

Санал

1. Даатгалын системд сэтгэл санааны хохирлын талаарх нөхөн олговрын эрсдэлийн үнэлгээг шинээр бий болгох түүнийг нийгэмд бодитойгоор хэрэгжүүлэх тал дээр гадны улс орны нийтлэг жишиг сайн туршлагыг нэвтрүүлэх

2. Эдийн бус хохирлын үнэлгээг тогтоодог хууль зүйн шинжилгээний тусгай лабораторийг ашигладаг болох - ЭХХШТХ-ийн 27 дугаар бүлэг, 27.1 дүгээр зүйлд гэмт хэргийн улмаас бусдад учирсан сэтгэл санааны хохирол буюу эдийн бус /нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, сэтгэл зүй, болон бие эрхтэнд үүссэн гэмтэл зовуурь, шаналал, өвчин буюу өвдөлтийн зэрэг/ хохирлын хэмжээг тогтоолгохоор нэхэмжилсэн тохиолдолд шүүх /шүүхийн шинжилгээг заавал хийлгэх/ эмнэлгийн дүгнэлт гаргуулах талаар тусган оруулах

3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлэгт нэмэлт, өөрчлөлт оруулан Сэтгэл санааны хохирлыг хэрхэн барагдуулах заалтыг тодорхой болгон оруулан журамлаж өгөх нь илүү ач холбогдолтой болгох

4. Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас эдийн болон эдийн бус хохирол учирсан иргэдэд Засгийн газрын зүгээс хохирол барагдуулах сан бий болгон тус сангаас нөхөн төлбөр олгох эрх зүйн боломжийг нээж өгч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

5. Бага насны хохирогчийн сэтгэл санаанд хүнд шарх үлдээдэг бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, түүнчлэн бие махбодын гэмтэлтэй холбоогүй боловч гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэцэд ноцтой эмгэг учирч, амьдралын чанарыг илтэд доройтуулсан тохиолдолд гаргуулах нөхөн төлбөрийн хэмжээг урьдчилан тогтоосон аргачлалыг боловсруулах

Ашигласан материал

I. Олон улсын гэрээ, Хууль, тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. УБ., 1946 он
3. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт. 1966 он
4. Иргэний хууль. УБ., 2002 он
5. Эрүүгийн хууль. УБ., 2015 он
6. Эрүүгийн хууль. УБ., 2019 он
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2015 он
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2019 он
9. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2002 он
10. Монгол Улсын хөрөнгийн тухай хууль. УБ., 2010 он
11. Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль. УБ., 1999 он

II. Ном, өгүүлэл, нийтэл

1. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг үндэслэл, Хүний эрх, шүүх эрх мэдэл, Нутгийн удирдлага. УБ., 2017 он
2. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн тусгай анги. УБ., 2011 он
3. Б.Буянхишиг. “Үүргийн эрх зүй (Ерөнхий анги), УБ., 2013 он
4. Иргэний эрх зүйн тайлбар толь: Ерөнхий анги, УБ., 2006 он
5. Н.Баярсүрэн, “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх ба гадаад орнуудын хуулийн зохицуулалт”, Монголын төр, эрх зүй №2, 2018 он
6. Ш.Оюунханд, “Сэтгэл санааны хохирол ба олон улсын хэм хэмжээ” Монголын төр, эрх зүй №3, 2013 он
7. А.Баярцэцэг, Гадаадын зарим орнуудын гэмт хэргийн улмаас учирсан эрүүл мэнд амь насны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөрийн тогтолцоо., Монголын төр, эрх зүй сэтгүүл., №4, 2018 он
8. Б.Зориг, Доромжлох гүтгэх гэмт хэргийг шийдвэрлэж ирсэн түүхэн уламжлал шинэчлэлийн асуудалд., Монголын төр, эрх зүй сэтгүүл., №1, 2015 он.